



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 09 сарын 17 өдөр

Дугаар А/125

Эг

Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх
дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, 9.9 дэх заалт, аймгийн Мал эмнэлгийн газрын даргын 2024 оны А/50 дугаар тушаал, аймгийн засаг даргын 2024 оны А/471 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг 2024 онд шинээр гарсан төл малыг бүрэн хамруулан 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрөөс эхлэн 20 хоногийн хугацаанд шуурхай зохион байгуулсугай.

2. Дархлаажуулалтын ажлыг чанартай, хуваарь, маршрутын дагуу хийж гүйцэтгэх, туслах ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж, зааварчлага өгч ажиллахыг Баянбараат хайрхан ХХК-ийн захирал Т.Бямбадорж -д үүрэг болгосугай.

3. Урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын ажилд мал сүргээ товлосон хугацаанд тарилгын хашаа бүхий газар авчирч бүрэн хамруулж, тарилгын явцад малын эмч мэргэжилтнүүдэд туслалцаа үзүүлэн хамтран ажиллахыг нийт малчдад, малчид, мал бүхий иргэдийг татан оролцуулж хүн хүчээр хангаж, мэдээлэл хүргэн, хяналт тавьж ажиллахыг багийн Засаг дарга нарт даалгасугай.

4. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх ажлын явцад мал сүргээ бүрэн хамруулаагүй, хамруулахаас зайлсхийсэн малчид, мал бүхий иргэд, заавар журмыг баримтлаагүйн улмаас өвчин гарах нөхцлийг бүрдүүлсэн албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага тооцож, хяналт тавьж ажиллахыг, мэргэжил арга зүйн заавар, зөвлөмжөөр хангаж ажиллахыг Мал эмнэлгийн улсын байцаагч Ж.Ундрах-д үүрэг болгосугай.

5. Дээрх аж ахуйн нэгжүүдэд олгох вакцины хуваарийг хавсралтаар баталсугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНСҮХ

202401351

Сумын Засаг даргын 2024 оны 09-р сарын 17-ны
өдрийн А/125 тоот захирамжийн хавсралт



2024 ОНД МЯЛЗАН ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
ДАРХЛААЖУУЛАЛТАД ХАМРАГДАХ МАЛ, ВАКЦИНЫ ХУВААРЬ

№	ААНэгжийн нэр	Малын тоо			Вакцин /тун/
		Хурга	Ишиг	Нийт	
1	Баянбараат хайрхан ХХК	8547	4653	13200	13.2
	Дүн	8547	4653	13200	13.2

ХУВААРЬ ГАРГАСАН:
МАЛ ЭМНЭЛГИЙН УЛСЫН БАЙЦААГЧ

Ж.УНДРАХ